



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 560

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.2.5, 6.4.3, 6.6, 6.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 8 нэрийн, нийт 271,910.92 (хоёр зуун далан нэгэн мянга есөн зуун арван ам.доллар ерэн хоёр цент) ам.долларын балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин Сайд, Ерөнхий консул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж устгах, данснаас хасах, худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2020 оны 11
дүгээр сарын 03-ны өдрийн
560 дугаар тогтоолын хавсралт

Монгол Улсаас гадаад улсад суугаа элчин сайдын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын, Хуримтлагдсан элэгдэл /ам.доллар/	ЭСЯ
1	Toyota Hais /микроавтобус/, D- 177/77 дугаартай, Арлын дугаар -JTFSX23PX06095857	2010/2010.01	152376	34,028.44	Москва ЭСЯ
2	Hyundai sonata 7 /суудлын/, A17802 дугаартай, арлын дугаар KMHEB41BVCA419191	2011/2012.01	140000	27,600.00	Хөх хот ЕКГ
3	Hyundai Starex микроавтобус /суудлын/, A17801 дугаартай, арлын дугаар KMJWA37RBBU369702	2011/2011.01	270000	27,654.96	Хөх хот ЕКГ
4	BMW 730 Li /суудлын/, Thor- 510001 дугаартай, арлын дугаар No10238004	2011/2012.02	36736	61,144.93	Бангкок ЭСЯ
5	Toyota-TRH213R /суудлын/- Thor-510002 дугаартай, арлын дугаар 2TR-8283990	2010/2010.08	100000	35,238.40	Бангкок ЭСЯ
6	Hyundai Starex микроавтобус /суудлын/, CD-3910 дугаартай, арлын дугаар D4CB8360222	2008/2008.01	168762	31,071.43	Сингапу р ЭСЯ
7	Mercedes-benz E320 /суудлын/ 06CD21-38 дугаартай, арлын дугаар-WDB2110261A664793	2004/2004.01	275594	41,305.00	Анкара ЭСЯ
8	Тоёото Эстима /суудлын/, GA196-07 дугаартай, арлын дугаар ACR50-7057407	2008/2014.01	144832	13,867.76	Токио ЭСЯ
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			271,910.92 (хоёр зуун далан нэгэн мянга есөн зуун арван ам доллар ерэн хоёр цент)	